

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН**

**“ЗУУН ДАМНАСАН ҮНДЭСНИЙ ХЭЛ БИЧГИЙН  
СУДЛАЛЫН ТҮҮХ”**

**СУУРЬ ХАВСАРГА СУДАЛГААНЫ ГРАНТААР  
ГҮЙЦЭТГЭСЭН ТӨСЛИЙН ТАЙЛАН**

<b>Төслийн удирдагч:</b>	<b>С.Байгалсайхан (Доктор, профессор)</b>
<b>Санхүүжүүлэгч байгууллага:</b>	<b>Шинжлэх Ухаан Технологийн Сан</b>
<b>Захиалагч байгууллага:</b>	<b>Шинжлэх Ухааны Академи</b>
<b>Тайлан өмчлөгч байгууллага:</b>	<b>Хэл зохиолын хүрээлэн Баянзүрх дүүрэг, Жуковын өргөн чөлөө ШУА-ийн Хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр. Утас: 451436, <a href="http://www.mas.ac.mn">www.mas.ac.mn</a> <a href="mailto:ill@mas.ac.mn">ill@mas.ac.mn</a></b>

**Улаанбаатар  
2022**

Улсын бүртгэлийн  
дугаар:

Нууцын зэрэглэл Б

Аравтын бүрэн  
ангиллын код

Төсөл хэрэгжүүлэх  
гэрээний дугаар: ШуАг-2020/13

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН**

**“ЗУУН ДАМНАСАН ҮНДЭСНИЙ ХЭЛ БИЧГИЙН  
СУДЛАЛЫН ТҮҮХ”**

**суурь хавсарга судалгааны грантаар  
гүйцэтгэсэн төслийн тайлан**

**Төслийн удирдагч:** С.Байгалсайхан (Доктор, профессор)

**Санхүүжүүлэгч байгууллага:** Шинжлэх Ухаан Технологийн Сан

**Захиалагч байгууллага:** Шинжлэх Ухааны Академи

**Тайлан өмчлөгч байгууллага:** Хэл зохиолын хүрээлэн  
Баянзүрх дүүрэг, Жуковын өргөн чөлөө  
ШУА-ийн Хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр.  
Утас: 451436, [www.mas.ac.mn](http://www.mas.ac.mn)  
[ill@mas.ac.mn](mailto:ill@mas.ac.mn)

**Улаанбаатар  
2022**

**Төслийн гүйцэтгэгчид:**

**Төслийн удирдагч:**

**С.Байгалсайхан (Доктор, профессор)**

**Төслийн гүйцэтгэгч:**

**Б.Мөнхбаяр (Дооктор)**

**Төслийн редактор:**

**Д.Цэрэнсодном** ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, “Монголын нууц товчоо” судлалын төвийн эрхлэгч, Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Төрийн шагналт, Академич

**Л.Болд** ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Алтай судлалын төвийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, БНТурк Улсын ШУА-ийн Хүндэт гишүүн, Академич

## ГАРЧИГ

<b>Реферат</b>		<b>5</b>
<b>I бүлэг:</b>	<b>Монголын шинжлэх ухааны байгууллагын уламжлал – Юань Улсын Бичгийн утгачийн улсын судар бичгийн хүрээлэн</b>	<b>7</b>
<b>II бүлэг:</b>	<b>Монгол Улсын шинжлэх ухааны байгууллага – Судар бичгийн хүрээлэн ба түүний Дуун ухааны тасаг (1921 - 1930)</b>	<b>10</b>
<b>III бүлэг:</b>	<b>Шинжлэх ухааны хүрээлэнгийн Хэл бичгийн кабинет (1930 - 1957) ба ШУДБХ-ийн Хэл утга зохиол судлах газар (1957 - 1961)</b>	<b>14</b>
<b>IV бүлэг:</b>	<b>Монгол Улсад Шинжлэх ухааны академи байгуулагдсан нь ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн (1961 оноос хойш)</b>	<b>17</b>
<b>Ерөнхий дүгнэлт</b>		<b>21</b>

## РЕФЕРАТ

2021 он: Монгол орны түүхэнд, тэмдэглэлт олон чухал үйл явдлын тэгш ой тохиосон билээ. Нэн түүхүүнээ Монгол орон Манжийн дарааллаас чөлөөлөгдөж, Богд Хаант Монгол Улсаа байгуулж, тусгаар тогтнолоо олсны 110 жил тохиосон билээ. Мөн түүнчлэн 1921 оны Ардын хувьсгалын 100 жилийн ойг дурдахгүй өнгөрч үл болно. 1921 онд Ардын хувьсгал ялснаар Монгол орны нийгэм эдийн засаг шинэчлэлийн замдаа туушдаа орж, өнөөгийн тусгаар тогтносон эх орныхоо үндэс суурийг тавьсан юм гэдэгтэй өнөө маргах хүн нэгээхэн ч үгүй биз ээ.


Тэгвэл ХХ зууны Монгол орны түүхэнд онцгой байр эзлэх нэгэн чухал үйл явдал болсон нь 1921 оны 11-р сарын 19-ний өдөр байгуулагдсан Судар бичгийн хүрээлэн хэмээх, орчин цагийн Монгол Улсын шинжлэх ухааны байгууллагын үндэс суурь нь болсон эрдэм судлалын байгууллага билээ. Судар бичгийн хүрээлэнгийн үндсэн нэгж нь Дуун ухааны тасаг байсан билээ. Тэгэхээр 2021 он нь Монгол Улсад орчин цагийн шинжлэх ухааны байгууллага үүсэн байгуулагдсан 100 жил, Дуун ухааны тасаг буюу Хэл зохиолын хүрээлэнгийн 100 жилийн тэгш дүүрэн ой тохиосон он болно.

Тиймээс бид Монгол Улсад орчин цагийн шинжлэх ухааны байгууллага Судар бичгийн хүрээлэн, түүний Дуун ухааны тасаг буюу Хэл зохиолын хүрээлэн байгуулагдсаны 100 жилийн ойгоо угтан, эл 100 жилийн ойдоо зориулан Монгол улсад үндэсний хэл бичгийн шинжлэх ухааны байгууллагынхаа үүсэл хөгжлийн түүхийг судлан шинжилж, шинээр үнэлэн дүгнэх зорилго бүхий “Зуун дамнасан үндэсний хэл бичгийн судлалын түүх” хэмээх суурь, хавсарга судалгааны грантаар гүйцэтгэх төслийг боловсруулан, удирдах дээд байгууллагадаа журмын дагуу дэвшүүлсэн болно.


Ийнхүү бидний төслийг хүлээн авч, асуудлыг шийдвэрлүүлэх үүрэг даалгавар өгснийг бид баяртайгаар хүлээн авч, грант төслөө амжилттай биелүүлсэн болно.

“Зуун дамнасан үндэсний хэл бичгийн судлалын түүх” хэмээх суурь, хавсарга судалгааны грантаар гүйцэтгэх төслийг **“Нэгэн зууны цадиг: Хэл зохиолын хүрээлэнгийн түүх”** (В 5 форматаар 319 нүүр хуудас, 26, 4 хх) нэртэйгээр бичиж дуусгав. Тус бүтээлийн үндсэн редактораар ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, “Монголын нууц товчоо” судлалын төвийн эрхлэгч, Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Төрийн шагналт, Академич Д.Цэрэнсодном, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Харьцуулсан хэл шинжлэлийн салбарын Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, БНТурк Улсын ШУА-ийн Хүндэт гишүүн, Академич Л.Болд нар ажиллаж үнэлэлтээ өгсөн болно.

Бид судалгааны грант төслөө 2021 оны 2-р сарын 20-нд бүрэн бичиж дуусган, улмаар Хэл зохиолын хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн 2021 оны 3-р сарын 12-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, хэвлэн нийтлэхийн зөвшөөрсөн тогтоолоо гардан авсан билээ. Түүнчлэн судалгааны явцын үр дүн болгож:



хэмээх өгүүллийг “Шинжлэх ухаан амьдрал” сэтгүүлд нийтлүүлсэн бол, 2021 оны 12-р сард зохион байгуулагдсан ХЗХ-ийн 100 жилийн ойд зориулсан ОУЭШХ-д илтгэл болгон хэлэлцүүлсэн нь сайшаалтай болсон билээ.



Мөн үүнээс гадна ШУА-ийн Грант мини симпозиумд грант аулынхаа үр дүнг амжилттайгаар бүрэн хэмжээнд танилцуулсан билээ.

13:00	Ботаникийн цэцэрлэгт тарималжуулж буй зарим өвслөг ургамлын эндо зүйлийн бүрдлийг тодорхойлох Ц.Мөнхзул, ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн, доктор (Ph.D)
13:20	Зуун дамнасан үндэсний хэл бичгийн судлалын түүх С.Байгалсайхан, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, доктор (Sc.D)
13:40	Оюуны өмч үнэлэх арга зүйн судалгаа П.Баянсан, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт
14:00	Бэлчээрийн төлийн гүзээндэх шаахайнцрын зүйлийн бүрэлдэхүүнийг талхуур бичиг-ном зохиох

## I бүлэг:

### Монголын шинжлэх ухааны байгууллагын уламжлал – Юань Улсын Бичгийн утгачийн улсын судар бичгийн хүрээлэн

Үүсгэн санаачилж, хэрэгжүүлсэн үйл хэргээрээ даян дэлхийн соёл иргэншлийн түүхэнд тод тэмдэглэгдэн үлдсэн Монголын нэгэн эзэнт гүрэн бол Хубилай сэцэн хааны үндэслэн байгуулсан Их Юань улс билээ. Хубилай хаан нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангахад, улс хүн ардын амьдралын төвшин амьжиргааг сайжруулах, улмаар улсаа тогтвортой хөгжүүлэхэд чиглэсэн олон бодлого баримталж байсны дотор шинжлэх ухаан, соёлын талаар онцгой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. Үүний нэг нь улсын багш Пагва ламаар Монголын шинэ үсэг буюу “Дөрвөлжин бичиг” зохиолгож, 1269 оноос улс даяар зарлан хэрэглэж, олон тооны сонгодог ном зохиолыг орчуулан хэвлүүлсэн явдал, нөгөө нь 1261 онд Юань Улсын “БИЧГИЙН УТГАЧИЙН УЛСЫН СУДАР БИЧГИЙН ХҮРЭЭЛЭН” буюу өнөөгийн ойлголтоор Шинжлэх Ухааны Академийг байгуулсан үйл хэрэг болно. “Бичгийн утгачийн улсын судар бичгийн хүрээлэн” байгуулсан нь Ази тивдээ лавтай анхдагчдын тоонд ордог түүхтэй.

“Бичгийн утгачийн улсын судар бичгийн хүрээлэн” буюу Юаны Шинжлэх Ухааны Академи нь төр улс, ард түмнийхээ өмнө дараах хэдэн үүрэг хүлээн гүйцэтгэдэг байжээ. Үүнд:

1. Өөрсдийнхөө, үндэстнийхээ туулж өнгөрүүлсэн үнэн түүхийг тэмдэглэх ба үүгээр дамжуулан өөрсдийгөө улам гүн танин мэдэж, улмаар ирээдүйн хөгжлийнхөө талаар зөв төсөөлөл, зөв үзэл баримтлалтай болохыг хичээж байлаа. Тийм учраас нэн түүрхнээ өвөг дээдсийнхээ, тухайлбал Есүхэй баатар, Чингис хаан, Өгөөдэй хаан зэрэг өнгөрсөн хаадынхаа түүх намтрыг бичиж эхэлсэн байна. Үүнийг “Ши жү” гэж нэрлэдэг байв. XVII, XVIII зуун болоход эл бүтээлийг “Магад хууль” гэж орчуулан нэрлэжээ. “Магад хууль” гэдэг бол “Уг тэмдэглэл”, “Үнэн тэмдэглэл” гэсэн утгатай болно. Тэгэхээр өвөг дээдсийнхээ туулж өнгөрүүлсэн үнэн, магад тэмдэглэлийг бичиж тэмдэглэснийг Магад хууль гэдэг байна.
2. Түүх бичлэгийн чиглэлээр, мөхсөн төр улсын түүхийг бичиж тэмдэглэн сударлах ажил эрхэлж байв. Тухайн үед гэхэд Киданы Ляо улс, Алтан улс нэгэнтээ мөхсөн байв. Сүн улсыг Юань улс мөхөөв. Эдгээр улсын түүхийг “Бичгийн утгачийн улсын судар бичгийн хүрээлэн”-ийнхэн, бичгийн нэрт мэргэд, чинсангууд багаараа оролцон бүтээсэн ба Ляо улсын түүхийг 116 боть, Алтан улсын түүхийг 135 боть, Сүн улсын түүхийг 496 ботиор бичсэн байна. Энэ бол, Монголчууд түүхэндээ анх удаа, бусдын түүхийг бичих хэмжээнд хүртэл хөгжсөнөө илтгэн харуулсан явдал болов. Тэд эдгээр түүхийг бичихдээ аль болох үнэн зөвөөр нь бичих зарчмыг баримталан бүтээжээ. Үүний зэрэгцээ эртний түүхийн ном зохиолыг цуглуулах, эх хэрэглэгдэхүүн бүрдүүлэх, хөмрөг фонд үүсгэж ажлыг давхар хэрэгжүүлж байлаа.
3. Түүхийн тавцанд Их Юань улс хэмээх нэгэн шинэ гүрэн байгуулагдсантай уялдан, нийгэм, соёл, танин мэдэхүйн хэрэгцээг бүх талаар хангахуйц шинэ бичиг үсэг зохиосныг дэлгэрүүлэх үүрэг хүлээсэн байлаа.

4. “Бичгийн утгачийн улсын судар бичгийн хүрээлэн”-ийн байгалийн ухааны чиглэл нь тусгай хүрээлэн сургуулиар одон орны судалгаа, зурхай, цаг тооллын бичиг гаргах ажлыг эрхлүүлдэг байв. 1291 онд Зурхайн сургуулийг байгуулж, Зурхайн ухаан төгс эзэмшсэн хүмүүсийг багшлуулдаг, сурлагаар тодорсон сурагчдыг жил бүр нийслэлд ирүүлэн шалгалт аваад, Одон орон судлах төвд ажиллуулдаг байжээ. 1267 онд Хубилай хаан Персийн одон орны нээлтээс мэдэхийн тулд Персийн одон оронч Жамал ад- Диныг хүрэлцэн ирэхийг урьсан ба тэрээр ирэхдээ, гараг эрхсийн байрлалыг хэмжих бөмбөрцгийн зураг тэмдэг, нарны цаг, өнцөг хэмжигч багаж, дэлхий ба тэнгэрийн бөмбөрцөг зэргийг хааны ордонд бэлэг болгон авчирчээ. Сүүлд дөрвөн жилийн дараа буюу 1271 онд Хубилай хаан Лалын одон орон судлах хүрээлэнг байгуулсан байдаг. Түүнчлэн Юань улсын хаан Аюурбалбад, Зурхайн ухаанд нэвтэрсэн мэргэдийг түшмэлд дэвшүүлэн ажиллуулах, тэдгээр хүмүүсийн хэргийг Одон орон судлах төвд хамааруулах шийдвэр гаргажээ. Тус төв нь од гариг, тэнгэрийн эрхэс, өдөр цаг, цагалбар зэргийг тодорхойлон гаргах үүрэгтэй албан байгууллага бөгөөд 1278 онд байгуулагдан, захирах түшмэл, мөн 7 туслах албаттайгаар үйл ажиллагаа явуулж байсан байна. Эл байгууллагын дэв зэргийг хоёрдугаар дэс гэж тогтоожээ. Хубилай хаан эн тэргүүнээ газар зүйн мэдлэг ухааныг хөгжүүлэхийг хөхиүлэн дэмжсэн бөгөөд түүний удирдлагаар олон тооны газрын зураг бүтээсэн билээ. Үүний үр дүнд “Глобус” хэмээн нэрлэгддэг дэлхийн бөмбөрцгийн анхны загварыг хийлгэсэн байдаг.

“Монгол Улсын Шинжлэх ухааны түүх” -нд Юань улсын “Бичгийн утгачийн улсын судар бичгийн хүрээлэн” хийгээд ер нь эртний Монголчуудын шинжлэх ухааны сэтгэлгээний хөгжлийг дараах байдлаар үнэлэн тодорхойлсон байна. Үүнийг үзвэл:

“Судар бичгийн хүрээлэнд монгол хэлний нийт 453 хүн ажиллаж байсны дотор монгол бичээч 108, монгол бичгийн хуулагч 34, түүхч орчуулагч 204 хүн байжээ. Монголын эзэнт гүрний үед “Монголын нууц товчоо”, “Судрын чуулган, Дөрвөн төрийн арван буянт номын Цагаан түүх”, Богд баатар биеэр дайлан тэмдэглэл” зэрэг түүхийн олон зохиол бүтээлүүд бичсэн нь өдгөө бидэнд анх бичигдсэн хэлээрээ үлдэж хоцроогүй боловч маш үнэ цэнтэй сурвалж болж байна. XIV зууны эхэнд монголын эрдэмтэн Чойжи-Одсэр эрдэм ухааны манлайд, хүрч, хэл шинжлэл, гүн ухаан, яруу найруулгын аргад гүнзгий мэргэшин, судар тарнийн аймгийн олон номыг монгол хэлнээ чадамгай орчуулан ихэд алдаршжээ. Чойжи-Одсэр, Монголын анхны үсгийн дүрэм, хэл зүйн зохиол “Зүрхэн тольт” хэмээх зохиолыг 1304 онд зохиожээ. “Зүрхэн тольт” хэмээх зохиол нь тэр цагтаа хэлний судлалын талаар хийсэн ихээхэн ололт бөгөөд уйгур үсгийг монгол хэлэнд зохицуулж, чухал шаардагдсан хэдэн үгсийг нэмээд, монгол үсгийн дүрмийн чухал асуудлыг тодорхойлон заажээ. Чойжи-Одсэр VII зууны үед Энэтхэгт зохиогдсон “Бодичарьяавадара” хэмээх гүн ухааны номыг 1306 онд шүлэглэн орчуулсан, бурхны шашны сургаал “Банзрагч” хэмээх судрыг 1308 онд орчуулан, төгсгөлийн шүлэг бичжээ. Мөн “Махгалийн магтаал” хэмээх зохиолыг шүлэглэн бичсэн бөгөөд шүлгийн уран яруу хэллэг шинэ өвөрмөц байдал нь орчуулгын зохиол биш, монгол шүлгийн бие даасан бүтээл хэмээн академич Ц.Дамдинсүрэн үзжээ”<sup>1</sup>

---

<sup>1</sup> Ч.Батдорж, Н.Хишигт, С.Чулуун “Монгол Улсын Шинжлэх ухааны түүх-1 боть”, УБ, 2021, 24-р тал



хэмээн онцлон тэмдэглэсэн байна. Ийнхүү нэгтгээд харах аваас: Их Юань улсын “Бичгийн утгачийн улсын судар бичгийн хүрээлэн” буюу Их Юань улсын Шинжлэх ухааны академи нь Хэл шинжлэл, Түүх, Одон орон, Газар зүйн ухаанаар салбарлан ажиллаж ирсэн нь, эртнээс Байгаль-Нийгмийн шинжлэх ухааны үндсэн салбарыг анхааран хөгжүүлж ирсний баримт болж байна. Энэ нь Их Юань улсын, Монголчуудын уламжлалт нүүдлийн болон суурин соёл иргэншлийн төгс зохицлыг тухайн цагтаа цогцлоосон, олон соёлын, олон хэлийн, олон угсаатны гүрэн байсантай нь ч холбогдох юм.

Хубилай хааны шинэчлэлийн бодлогын цөм нь үндэс угсаа, шашин шүтлэг, гадаад дотоодыг үл харгалзан, харин хэн их номтой, хүч чадалтай, эрдэм ухаантай, билиг оюунтай байна түүнийг дэмжиж, өндөр цалин хөлс өгч, улсынхаа төрд үйлчлүүлж байх мэргэн бодлогыг баримталж, улмаар эл бодлогоо улсынхаа “Бичгийн утгачийн улсын судар бичгийн хүрээлэн” буюу Их Юань улсын Шинжлэх ухааны академидаа нэн түрүүн хэрэгжүүлсэн нь улсынх нь хөгжлийн хөдөлгөгч хүчин болсон байна. Энэ байдлыг дагаад Юаны соёл, шинжлэх ухааны асуудал байр сууриа эзэлж, асуудлыг шийдвэрлэх албан ёсны эрдмийн хүрээлэн буюу Шинжлэх ухааны академи нь байгуулагдсан, зохион байгуулалтын хувьд тогтон төлөвшсөн байв. Гийм ч учраас өнөөгийн Монгол Улсын ШУА, Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан гадаад, дотоодын эрдэмтдэд олгодог дээд шагнал “Алтан медаль”-аа “Хубилай хаан” хэмээн нэрлэсэн нь Хубилай хааны үүсгэн байгуулсан “Бичгийн утгачийн улсын судар бичгийн хүрээлэн”-гийн үйл хэрэг, уламжлал үнэт зүйлээр бахархан, түүнийгээ үнэлэн дээдэлсэн хэрэг мөн.

“Бичгийн утгачийн улсын судар бичгийн хүрээлэн”-ийн гүйцэтгэж ирсэн ажил үүрэг, судалгааны ном бүтээлээс дараах хоёр үндсэн байдал ажиглагдана. Үүнд:

1. “Бичгийн утгачийн улсын судар бичгийн хүрээлэн”-ийн, гүрэн улс, хаад ноёд, ихэс дээдсийнхээ үнэн түүхийг тэмдэглэсэн судар тэмдэглэл, магад түүх зэрэг нь Уран зохиол судлалын талаасаа Түүхэн баримтат зохиол болох юм. Түүхэн баримтат зохиол гэдэг бол аль нэгэн түүхэн хүн эсвэл онцгой түүхэн үйл явдлыг гол зангилаагаа болгож тэр түүхэн баримтыг уран сайхнаар боловсруулан бичсэнийг хэлдэг. Тэгэхээр эндээс баримт-уран сайхны харьцаа, баримтыг уран сайхнаар хэрхэн боловсруулах тухай онол, туурвил зүйн асуудал гарч ирж байгаа бөгөөд эртний түүхэн зохиол бүтээл дэх бодит баримтыг яаж үзүүлсэн туршлагыг судлан тодорхойлж болно гэсэн үг юм. Мөн нөгөө талаас үндэсний бичгийн утга зохиолын төрөл зүйлс, тухайлбал судар, толь, шашдир, товчоо, эрих, цадиг, намтар, туужийн онцлог, харилцан нөлөөлөл, уялдаа холбоо болон эдгээр төрөл зүйлийн бүтээлийн өнөө цагийн ул мөр, уламжлал шинэчлэлийн харилцаа зэрэг олон асуудлыг сөхөж болно.
2. Юань улсын төрийн шинэчлэлийн бодлогын бодит биелэл нь болсон “Дөрвөлжин бичиг”, түүний хэрэглээний асуудал. Дөрвөлжин бичиг, түүний түгэн дэлгэрэлт, хэрэглээний асуудал нь Монгол бичиг үсэг, соёлын түүхэнд чухал байр эзэлдэг. Хэл шинжлэлд “Phags-pa script”, “Square script”, “Квадратная письменность” зэрэг нэршлээр үндсэн судлагдахууных нь нэг болж төлөвшжээ.

## II бүлэг:

### Монгол Улсын шинжлэх ухааны байгууллага – Судар бичгийн хүрээлэн ба түүний Дуун ухааны тасаг (1921 - 1930)

Аливаа улсын шинжлэх ухааны байгууллага нь тухайн төр улсынхаа оюуны гол цөм нь байдаг билээ. Тийм ч учраас төр засгийн зүгээс улс орныхоо хөгжил дэвшил, ирээдүйн сайн сайхны төлөө асуудлыг шийдвэрлэхдээ, ард иргэдээ соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх их үйлсийг гүйцэтгэхдээ ямагт шинжлэх ухааны үнэн, зөв мэдлэг мэдээлэлд тулгуурладаг. Ялангуяа тусгаар тогтнолоо дөнгөж олж, шинэ тулгар байгуулагдсан, нийгэм эдийн засгийн хөгжлийн хувьд сул дорой, дотоод, гадаад орчин нөхцөл нь таатай бус, мэдлэг боловсролтой хүн ам цөөтэй, орчин үеийн шинжлэх ухааны ойлголт, ололт, хөгжил дэвшлээс хол хөндий, ард түмэн нь энгийн номхон, сэтгэл зүйн хувьд хаашаа ч хувирч болох тийм онцгой цаг үед, шинжлэх ухааны үнэн, зөв мэдлэг мэдээлэлд тулгуурлах нь нэн хэрэгцээтэй, тулгам шаардлага болж ирдэг зүй тогтолтой аж. Тэгвэл цаг үе, нийгэм түүхийн нэгэн ийм нөхцөл, тохироо бүрдэн эвлэсэн үе нь 1921 он байлаа.

1921 оны 7-р сарын 11-нд Үндэсний ардчилсан хувьсгалыг удирдан зохион байгуулж, амжилтанд хүргэсэн хувьсгалын зүтгэлтэдийн нэг Бодоогийн Засгийн газар байгуулагдав. Түүний Засгийн газрын бүрэлдэхүүнд тухайн үеийн улс төрийн хүчнүүдийн төлөөллүүд багтсан байдаг ба “Ерөнхий сайд ба Гадаад яамны тэргүүн сайдад Их шавийн Д.Бодоо, Дотоод яамны тэргүүн сайд, нэгэн оронд их шавийн Да лам Пунцагдорж, Дэд сайд нэгэн оронд, БУРИАД ГҮН ЦЭВЭЭН ЖАМСРАНОВ, Эрхэлсэн түшмэл Сэцэн хан аймгийн эрх гүн Пунцагдалайнамжилын хошууны түшмэл Догсом, Ёслолыг удирдагч түшмэлд Түшээт хан аймгийн Эрдэнэ дайчин ван Жамбалдоржийн хошууны бэйс Гомбосүрэн, Гадаад яамны дэд сайд нэгэн оронд Сэцэн хан аймгийн үнэн сүжигт Илдэн ван Доржпаламын хошууны гүн Жигмэддорж, Эрхэлсэн түшмэлд, Их шавийн хичээнгүй бэйс Цэрэндорж, Цэргийн яамны тэргүүн сайд бөгөөд Бүх цэргийн жанжинд Сүхбаатар, Дэд жанжинд Сайн ноёнхан аймгийн Хатан баатар ван Магсаржав, Эрхэлсэн түшмэлд Сэцэн хан аймгийн Чин ачит ван Тогтохын хошууны бэйс Гомбо-Идшин, Сангийн яамны тэргүүн сайдад Данзан, Дэд сайд нэгэн оронд ИХ ШАВИЙН ГҮН ЖАМЪЯН, Эрхэлсэн түшмэлд буриад гүн Цэдэн-Иш, Шүүх яамны тэргүүн сайдад Их шавийн бэйл Магсаржав хурц, Дэд сайдад Сайн ноён хан аймгийн Батсүхийн хошууны гүн Тогтох, Эрхэлсэн түшмэлд мөн аймгийн Ёст бэйс Чүлтэм агсаны хошууны Дагвасамбуу, Шадар сайдад Да лам Пунцагдорж, Эрдэнэ ван Намсрай, Сэцэн ван Гүрсоронзонгомбосүрэн, Дайчин жонон ван Цогбадрах, Баатар ван Базарваань, Гүн Дэндэв”<sup>2</sup> нар оржээ.

Засгийн газрын бүрэлдэхүүнийг тэр үеийн аймгаар нь хуваавал, Түшээт хаан аймаг Их шавиас бараг 80 хувь нь, үлдсэн хорин хувьд Сэцэн хан аймаг, Сайн ноён хаан аймгийн зэрэг хэргэм өндөр язгуурын ноёд багтсан нь ард түмнээ гэгээрүүлэх, мэдлэгжүүлэх, соёлжуулах бодлогыг хэрэгжүүлэхэд, мөн энэ чиглэлийн бусад үйл ажиллагаанд санхүү, хөрөнгө оруулалт хийхэд эерэг байдлыг бий болгов. Учир нь эдгээр ихэс ноёд цөм гэрийн сургууль болон бусад хэлбэрийн сургуулиар бичиг эрдэмд суралцсан, улс орныхоо үүх түүх хийгээд ертөнц дэлхий, хүн, нийгмийн амьдралын жам

<sup>2</sup> Н.Магсаржав. “Монгол Улсын шинэ түүх”. УБ. 1994. 218- 219-р тал

ёс, учир утгыг тайлбарлан таниулсан ном судрыг сайн мэддэг, тэр хэрээрээ бүс нутаг, олон улсын болон улс орныхоо байдлын талаарх мэдээлэлтэй, алс хэтийн хөгжил дэвшлийн талаарх үзэл баримтлалтай, нийгэм улс төрийн зүтгэлтнүүд байсан. Тэд, хөгжил дэвшилд юуны өмнө гэгээрэл боловсрол хэрэгтэй гэдгийг, тухайн үеийн Монгол орноо хоцрогдол харанхуйн ангалаас ямар үйл хэргийг, ямар үе шаттайгаар, яаж өрнүүлвэл хурдан гарах вэ? гэдгийг сайн мэдэж байсан тул, хэдий улс төр, нийгэм, эдийн засгийн нөхцөл хүнд төвөгтэй байсан ч гэлээ, шинжлэх ухаан, танин мэдэхүй, гэгээрлийн албан ёсны байгууллагатай болохыг цөм дэмжицгээв.

Нөгөө талаар Д.Бодоогийн Засгийн газрын бүрэлдэхүүнд Жамъян гүн, Ж.Цэвээн зэрэг эрдэм номын мэргэд орсон нь, бодож санаж байсан шинжлэх ухаан, соён гэгээрүүллийн үйл ажлаа өрнүүлэхэд, үүнийгээ Засгийн газрын гишүүдэд зөв таниулж ойлгуулахад, цаашлаад Засгийн газраар дэмжүүлэхэд бүр ч нааштай алхам болж өгсөн нь дамжиггүй.

Ингээд 1921 оны 7-р сарын 11-нээс хойш 4 сар өнгөрөхөд санаачлагч талын идэвхитэй ажиллагаа, засгийн бодлогын дэмжлэгийн үр дүнд, Монгол Улсын Засгийн газрын 1921 оны 11-р сарын 9-ны өдрийн хурлаар “Номын хүрээлэн” байгуулах тухай шийдвэрлэж, Сангийн яамны Дэд сайд Их шавийн гүн Жамъян, Дотоод яамны Дэд сайд, буриад гүн Цэвээн Жамсранов нарт “Номын хүрээлэн”-ийн дүрмийн төслийг боловсруулахыг даалгав.

О.Жамъян, Ж.Цэвээн нар эл үйл хэргийнхээ талаар санаа бодол нэгт төрийн зүтгэлтэн, бичиг соёл, номын мэргэд Б.Цэрэндорж, Бат-Очир шадар, Их говийн Дорж мэйрэн, Дашням гүн, Дандаа чинсан Дэмчигдорж... нартай нарийн тунгаан зөвлөлджээ.

Ингээд О.Жамъян гүн, Ж. Цэвээн, Бат-Очир шадар нар хоёр хоногийн дотор, номын мэргэд дотно нөхдийнхөө илэрхийлсэн санал, үзэл баримтлалыг тухайн үеийн дэлхийн шинжлэх ухааны байгууллагын дэвшилтэт үзэл санаатай хослуулан тусгах, гүйцээн боловсруулах ажлыг гардан гүйцэтгэж, “Судар бичгийн хүрээлэнгийн дүрэм” хэмээх нийт 15 зүйл бүхий баримт бичгийн төслийг бэлэн болгосон байна. Боловсруулсан дүрмийн төслийг толилуулбал:

- “§ 1: Монгол ардын Засгийн газраас зарлигаар тусган Судар бичгийн хүрээлэн байгуулж, гадаад олон улсын хэлнээс монгол хэлэнд зүйл бүрийн ухааны ба улс төрд хэрэглэгдэх судар бичгүүдийг орчуулгаж авах ба уул монгол хэлээр зохиож дэлгэрүүлэх зэрэг явдлыг эрхэлмүй. Жич, Хүрээлэнгийн газраа дэлхий дахины улсын бичиг, судрын сан ба музей хэмээх зүйл бүрийн сонин зүйлийг хурааж, олон хүн үзэж танихуйд тус болгомуй хэмээхээс гадна, Монгол газрын элдэв зүйлийн хуучин ном судруудыг олж, бүрэн бүтэн хадгалах ба монгол үндэстэнд чухал холбогдох хэргийн бичигтэй хөшөө, чулууны зэрэг зүйлүүдийг батлан хамгаалмуй.
- § 2: Хүрээлэнгийн жинхэнэ гишүүдийг анх удаа Засгийн газраас сонгон тавимуй. Энэхүү Хүрээлэнд эрхэлсэн сайд, нарийн бичгийн дарга, гишүүд байвал зохимуй.
- § 3: Энэхүү Хүрээлэнд тусгай тамга тэмдэг олгомуй.

- § 4: Аливаа судар бичиг орчуулах, зохиох, дэлгэрүүлэх, хураах, гишүүн нэмэх, хэлтэс байгуулах эрдэмтэн мэргэдийг сонгон авах, урих, хөлслөх, дотроо хэрэглэх дүрэм хэмжээг тогтоох зэргийн хэргийг Хүрээлэн өөртөө мэдэх эрх буй.
- § 5: Хүрээлэнгийн дотор өөртөө хуралдах хурлаас гадна, аливаа эрдэмтэн оюутныг цугларуулж харьяат Хүрээлэнгийн зохиосон ба бусад мэргэдийн зохиол зэргийг сонгож шүүмжлэн хэлэлцүүлмүй.
- § 6: Хүрээлэнгийн аливаа эрдэм боловсролын тухай гадаад улсын Судар бичгийн хүрээлэн ба эрдэмтэн лүгээ харилцан нэвтрэлцэх эрх буй.
- § 7: Хүрээлэнгийн доторх аливаа айлтгаваас зохих хэргийг Монгол улсын дүрмийн ёсоор айлтгах эрх буй.
- § 8: Хүрээлэнгийн жинхэнэ гишүүд Улсын хуралд оролцох эрх буйгаас гадна, харьяат Хүрээлэнгийн гишүүдийг аливаа олон яамны зэрэг бусад газраа давхарлан албан хаалгах үгүй болгомуй.
- § 9: Хүрээлэнгийн газраас орчуулсан, зохиосон, шинжилсэн, олсон эл судар бичгийн дотроос чухал хэрэглэгдэх зүйлийг нь хэвлэн тараамуй.
- § 10: Энэхүү Хүрээлэнд аливаа орчуулсан зохиосон зүйлүүдийг цөм Судар бичгийн хүрээлэнгийн чухам хөрөнгө болгомуй.
- § 11: Анхан удаа Хүрээлэн байгуулахууд тохирох орон байшин, сав хэрэглэл зэргийг Засгийн газраас заан бэлтгэн хэрэглүүлэхээс гадна, жил бүрийн зардал мөнгийг урьдаас төсөвлөн бодож, хэрэглэх тоог тодорхойлон гаргаж, Засгийн газраа мэдүүлэн батлахыг үзэж, Сангийн яамнаас тавин олгомуй.
- § 12: Хүрээлэнгээс урьж ирсэн эрдэмтний суух орон, түлш, гэрэл ба явах замын хэрэглэл зэргийг сангаас олговол зохимуй хэмээхээс гадна, харьяат Хүрээлэнгийн эрхэлсэн сайдыг хоёрдугаар, гишүүд ба нарийн бичгийн даргыг гуравдугаар зэрэгт адилтгамуй.
- § 13: Хүрээлэнгийн бүх орсон, зарсан мөнгөн зүйлийн тоог жилийн эцэст тайлан бодож, Сангийн яаманд явуулж, хянан байцаалгамуй.
- § 14: Хүрээлэнгийн аливаа явдал, үйлдвэрт Засгийн газраас онц туслан хамгаалмуй.
- § 15: Үүнээс дээш бичсэн Хүрээлэнгийн дүрэм хэмжээ, зүйлүүдийг цөм цагийг дагаж зарлуулан хувьсгаваас болмуй хэмээн хэлэлцээнийг толилон тогтоохыг гуйсугай”<sup>3</sup>

гэжээ. Дүрмийн төслийг шинжлэх ухаан судлалын үүднээс авч үзвэл, эх орондоо шинжлэх ухааныг хөгжүүлэх, ингэхдээ дэлхийн дахины дэвшилтэт жишгийг нутагшуулах, шинжлэх ухааны салбарын ажилтныг дэмжих, тодорхой түвшний эрх мэдэл эдлүүлэх, үүнийхээ хэрээр гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэн, хариуцлагажуулахад анхаарсан нь ажиглагдана. Ингэхдээ хүрээлэнгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, эрхлэн гүйцэтгэх ажлын хүрээ, байгууллагын төсөв, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хэрхэн санхүүжүүлэх, ажлын байрны орчин, өөрийн мэдлийн өмч хөрөнгөө яаж бүрдүүлэх, гишүүдээ яаж сонгох, эх орны соёлын биет ба биет бус үнэт өвийг яаж судлах, хамгаалах хийгээд гадаад, дотоод хамтын ажиллагаа зэрэг АКАДЕМИК шинж бүхий өргөн агуулгыг багтаасан байна.

<sup>3</sup> “Шинжлэх ухааны хүрээлэнгийн түүхэнд холбогдолтой баримт бичгүүд”, “Шинжлэх ухаан” сэтгүүл №3, Улаанбаатар, 1956, 49-р тал

Энд нэгэн сонирхолтой асуудал байгаа нь дүрмийн төслийнхөө нэрийг “Номын хүрээлэнгийн дүрэм” гэлгүй, “СУДАР БИЧГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ДҮРЭМ” гэж нэрлэсэн явдал юм. Өөрөөр хэлбэл байгууллагаа “Номын хүрээлэн” гэж биш “СУДАР БИЧГИЙН ХҮРЭЭЛЭН” хэмээн нэрлэхээр шийдсэн байгаа юм.

“СУДАР БИЧГИЙН ХҮРЭЭЛЭН” хэмээн нэрлэхэд голлох нөлөө үзүүлсэн хүн нь Б.Цэрэндорж, хожим Судар бичгийн хүрээлэнгийн гишүүн болсон Дандаа чинсан Дэмчигдорж нар ажээ. Б.Цэрэндорж бол “Хичээнгүй” хэмээх цол хүртсэн, төрийн нэрт зүтгэлтэн билээ. Тэрээр “Судар бичгийн хүрээлэн гэж бичиг зохиол зэргийг судалдаг эрдэмтний газар юм”<sup>4</sup> гэж томъёолж, зөвлөн тайлбарлаж байсан бол, Дандаа чинсан Дэмчигдорж 1917 оноос эхлэн “Юань улсын судар” хэмээх 120 дэвтэр сурвалж бичгийг хятад хэлнээс орчуулсан ба “Юань улсын судар”-т, шинжлэх ухааны байгууллагаа “БИЧГИЙН УТГАЧИЙН УЛСЫН СУДАР БИЧГИЙН ХҮРЭЭЛЭН” гэж нэрлэж байсныг, уламжлан хадгалж, улмаар шинэчлэн залгамжлах үүднээс, шинээр байгуулж буй “Номын хүрээлэн”-гээ “СУДАР БИЧГИЙН ХҮРЭЭЛЭН” гэж нэрлэх зэрэг санал дэвшүүлснийг нь, номын мэргэд, хамтран зүтгэгч О.Жамъян, Ж.Цэвээн тэргүүт нөхөд нь зөвшөөрч, тийнхүү “СУДАР БИЧГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ДҮРЭМ” хэмээн нэрлэхээр төсөлдөө тусгажээ.

Ингээд 1921 оны 11-р сарын 11-ний өдөр “Судар бичгийн хүрээлэнгийн дүрэм” хэмээх нийт 15 зүйл бүхий төслийн баримт бичгийг Засгийн газарт өргөн мэдүүлснийг, Засгийн газар 1921 оны 11-р сарын 19-ны өдрийн 24-р хурлаараа авч хэлэлцээд,

“Монголын Нийслэл Хүрээнд Судар бичгийн хүрээлэн байгуулахаар төлөвлөсөн дүрэм хэмжээ маш зүйтэй болсон”<sup>5</sup>

гэж үзсэн тул ёсоор болгон баталж, эрхлэх сайдыг Засгийн газраас сонгон томилж, айлтган тогтоолгох ба “Судар бичгийн зүйлд энэ удаа хэрэглэх гурван мянган ланг Засгийн газраас Сангийн яамнаа хуудас явуулж, тавин олгуулах<sup>6</sup>-аар тогтжээ.

Ингэж шинэ цагийн Монгол Улсын түүхэнд, орчин үеийн шинжлэх ухааны байгууллага бий болж, Засгийн газраас үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрлийг нь өгчээ.

---

<sup>4</sup> Б.Ринчен “Монгол бичгийн хэлний зүй” тэргүүн дэвтэр, (удиртгал), УБ, 1964, 143-р тал

<sup>5</sup> Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд (баримт бичгийн эмхэтгэл) Эмхэтгэсэн Ц.Насанбалжир, УБ, 1954, 189-р тал

<sup>6</sup> “Шинжлэх ухааны хүрээлэнгийн түүхэнд холбогдолтой баримт бичгүүд”, “Шинжлэх ухаан” сэтгүүл №3, УБ, 1956, 46-р тал

### Ш бүлэг:

#### Шинжлэх ухааны хүрээлэнгийн Хэл бичгийн кабинет (1930 - 1957) ба ШУДБХ-ийн Хэл утга зохиол судлах газар (1957 - 1961)

1930-1957 он гэдэг бол Монгол Улсын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн нийт ажилтан, хамт олон, түүний дотор Хэл бичгийн кабинетын эрдмийн хамт олон, номын олон мэргэдийн хувьд амьдрал хувь заяа, ажил, үйл хэргийнх нь хувьд онцгой нэгэн үе байсан юм.

Дэлхийн соёл иргэншил, бичиг үсэг, утга соёлын хөгжил дэвшилд Монголчуудын оруулсан хувь нэмэр болох Монгол бичиг, Дөрвөлжин бичиг, Соёмбо үсэг, Хэвтээ дөрвөлжин үсэг, Тод бичиг, Вагиндрагийн үсэг, Латин үсэг, Кирил үсэг ... зэргээс Хэл бичгийн кабинетын жилүүдэд гурав нь Монгол Улсын албан ёсны бичиг байж, Монголын ард түмэн идэвхитэй хэрэглэж, тэр хэрээрээ кабинетын ажилтнуудын ном бүтээл, судалгаа нь нэг талаас уламжлал шинэчлэлийн харилцаа холбооны бодит илрэл, нөгөө талаас эх орныхоо хөгжил дэвшилд нийцсэн орчин үеийн, шинэлэг байх шаардлагыг хангаж байлаа.

Дэлхийн II дайн дэгдэж, тэр цаг үеийн Монголын нийгмийн сэтгэлгээ, Монголын ард түмний сэтгэл зүйд томоохон нөлөөгөө үзүүлж эхлэх үед Шинжлэх ухааны хүрээлэнгийн Хэл бичгийн тасгийн эрхлэгч Ц.Дамдинсүрэн эзэн Чингис хааны баатарлаг тэмцлийн түүхийг өгүүлдэг “Монголын нууц товчоо” бүтээлийг орчин цагийн монгол хэлэнд орчуулан хэвлэсэн бол Хэл бичгийн кабинетын ажилтан Б.Ринчен “Цогт Тайж” хэмээх эх оронч, баатарлагийн агуулга бүхий бүтээлээ гаргаж, эх орон ард түмнээ сэтгэлийн хаттай, зориг тэвчээр тууштай эх оронч, баатарлаг үзэл санаатай байлгахад чухал хувь нэмэр оруулсан байна.

Орчин цагийн Монголын шинжлэх ухааны түүхэнд хэл бичиг судлал, хэл шинжлэлийн ухаанаар анх удаа эрдмийн зэрэг хамгаалсан эрдэмтэд тус кабинетаас төрсөн гарсан нь өдгөө Хэл бичгийн кабинетын үйл хэргийн залгамжлал болсон ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн бахархал байхаар үл барам, ерөөс Монголын Шинжлэх ухааны академи, Монголын ард түмэн, Монгол Улсын бахархал, үнэт зүйл болсон байна.

Түүнчлэн ШУХ-ийн Хэл бичгийн кабинетын эрдэмтэн судлаачдын оролцоо дэмжлэгтэйгээр орчин үеийн мэргэжлийн, хэл бичиг уран зохиол судлаач - үндэсний шинэ боловсон хүчин бий болж, Монгол хэл, Монгол утга соёл, үндэсний өв уламжлалд хандах нийгмийн сэтгэлгээ эерэг хандлагатай болсныг онцлон тэмдэглэх ёстой.

Мөн энэ үйл явцын хамт Хэл бичгийн кабинетын эрдэмтдийн гадаад нэр хүндийн ачаар гадаад Монголын хэл соёлыг сонирхон судлах явдал шинэ шатанд гарч, Дэлхийн “Монгол судлал” хэмээх эрдэм ухааны нэгэн том давалгаа шинэ маягаар хүчээ авсан, онцлог үе байсан билээ.

Энэ мэт эрдэм судлалын олон сайхан үйлсийг Монгол Улсын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Хэл бичгийн кабинетын эрдмийн хамт олон бүтээж ирсэн ч, Монголын нийгмийг бүхэлд нь хамарсан хэлмэгдүүлэлтийн хар шуурга тэднийг дайрч, үүнд олонх нь өртөн, цаг бусаар хорвоог орхиж, эсэн мэнд үлдсэн нь эрдэм судлалын үйл ажиллагааны

эрхээ удтал хасуулж, уламжлал шинэчлэлийн тасалдангуй байдал үүссэн нь манай хэл бичиг судлал, хэл шинжлэл, утга зохиол судлалд төдийгүй үндэсний шинжлэх ухааны хөгжил, түүний онол, арга зүйн сэтгэлгээнд бодитойгоор нөлөөлөх болсон юм.

Гэсэн ч шинжлэх ухааны онол арга зүйн сэтгэлгээний тэр хоосрол, орон зайг билиг ухааныхаа ачаар голомтдоо үлдэж чадсан номын мэргэд маань, эх орныхоо төлөөх хатуу зорилго, чин сэтгэл, нөр их хөдөлмөр зүтгэлээрээ нөхөн гүйцээж, дахинтаа бадраан, мандуулж чадсан билээ.

1957 онд Шинжлэх ухааны хүрээлэн болон их, дээд сургуулиудыг нэгдсэн удирдлагаар хангах, хоорондын харилцаа, онол практикийн нийлэмж холбоог нь зохицуулах үүрэг бүхий “Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэн”-г байгуулсны чухам цаад үндэс нь тухайн үеийн нийгэм эдийн засгийн хөгжилд үнэлгээ хийсний үндсэн дээр, улс орны хөгжлийн дараагийн шатны шинэ гарааг эхлүүлэхэд бэлтгэж өгсөн хэрэг байв.

1940 оны 6-р сард БНМАУ-ын VIII их хурлаар II үндсэн хуулиа батлан, улсын сүлд, далбаа бэлгэдлээ өөрчлөн, Монгол орноо “Хөрөнгөтний бус замыг сонгосон ардын тусгаар улс” хэмээн тодорхойлон, хөгжлийн шинэ зорилтоо томъёолов. Тийнхүү шинэ зорилтоо биелүүлэхийн тулд албан журмын татварын хуулийг мөрдөх, ардын боловсролыг хөгжүүлэх, бүх шатны боловсролын байгууллага байгуулах, төрийн мэдэлд байлгах, үйлдвэрлэлийг хөгжүүлэх шат дараатай бодлого хэрэгжүүлсэн байна. 1947 онд хуралдсан МАХН-ын XI их хурлаар БНМАУ-ын улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх анхдугаар таван жилийн төлөвлөгөөг баталж, бүтээн байгуулалтын ажлыг тодорхой тогтолцоо судалгаа шинжилгээний үндэслэлтэйгээр явуулахыг шаардаж, энэ хэрээр судалгаа шинжилгээ шинжлэх ухааны асуудлууд дэвшигдэн гарч, нийгмийн амьдрлын өөрчлөлт хурдацтай ахин дэвшин, улам бүр орчин үежиж эхэлсэн байна.

1949 онд Улаанбаатар Наушкийн, 1956 онд Улаанбаатар Замын үүдийн төмөр зам тавигдаж, эх орны гурилын хэрэгцээг бүрэн хангах зорилттой уялдан, атар газар эзэмших хөдөлгөөн өрнөж, суурин соёл иргэншлийн хэв маяг бүрдэж эхлэв. Улс орны гадаад нэр хүнд өсөн дээшилж, гадаад хамтын ажиллагаанд БНХАУ-тай байгуулсан эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээ чухал үүрэг гүйцэтгэж эхэлжээ.

Үндэсний их дээд сургуулийн тогтолцоо бий болж, эх орныхоо хөгжилд бодит хувь нэмэр оруулж эхлэв.

Монгол улсын хүн ам өсөн нэмэгдэж 1956 онд 2-р сарын 15-ны байдлаар 845.500-д хүрэв. Энэ бүхэн бол үндсэндээ 1940 оны үндсэн хуулийн 1-р зүйлд заасан:

“Бүгд Найрамдах Монгол Ард Улс болбоос эзэрхэг түрэмгий ба феодалын дарлалыг устгасан, цаашид нийгэм журамд дэвшин орохын учир улс орон юугаа хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдлыг хангаж бүхий хөдөлмөрчин (малчин, ажилчин, сэхээтэн) ардын тусгаар тогтносон улс мөн болно”

хэмээх зорилгоо бүрэн хангасан хэрэг байлаа. Өөрөөр хэлбэл 1957 оноос хөгжлийн явц байдлаа үнэлэн дүгнэх, дараагийн шатны гараагаа тодорхойлох үйл явц өрнүүлэх шаардлага гарсан, хөгжил, дэвшлийн нэгэн зааг үе эхэлсэн ажээ. Ийм учраас ШУХ-г “Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэн” болгож, хөгжлийн зорилттой уялдуулан шинэчлэн байгуулсан ба Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэнгийн үндсэн газрын нэг нь хэлбичгийн ухааны доктор, профессор Б.Ринчен захиралтай “ХЭЛ, УТГА ЗОХИОЛ СУДЛАХ ГАЗАР” байв.

Хэл, утга зохиол судлах газар нь орчин үеийн шинжлэх ухааны байгууллага, хүрээлэн төвийн үндсэн үйл ажиллагааны хэв шинжийг бүрэн хадгалсан, Монгол хэл бичгийн шинжлэх ухааны хөгжил дэвшил, уламжлал шинэчлэлийн бодит гүүр нь болсон, Монгол хэл бичгийн шинжлэх ухаан хийгээд эрдэмтдийн гадаад, дотоод нэр хүндийг өндөрт өргөсөн, энэ хэрээрээ Монголын шинжлэх ухааны байгууллагын үндсэн имижийг тодорхойлсон газар болсон байжээ.



#### IV бүлэг:

### Монгол Улсад Шинжлэх ухааны академи байгуулагдсан нь ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн (1961 оноос хойш)

Судар бичгийн хүрээлэн (1921) -ээс Шинжлэх ухааны хүрээлэн (1930), Шинжлэх ухааны хүрээлэнгээс Шинжлэх ухаан дээд боловсролын хүрээлэн (1957), Шинжлэх ухаан дээд боловсролын хүрээлэнгээс ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ (1961) болж, ахин дэвшсэн нь нэг талаар улс орны түүхэн хөгжилтэй холбоо бүхий нийгмийн шинэчлэлийн цогц бодлогын үр дүн мөн гэлээ ч, эх оронд шинжлэх ухаан, тэргүүний технологийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны төв байгууллага ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ байгуулагдсан нь түүхэн үзэгдэл байсан юм.

Тухайлбал: 1940 онд баталсан Монгол Улсын II Үндсэн хуулиар томъёолсон зорилго, зорилт нь биелсний бодит илрэл нь, Монгол орны нийгэм эдийн засаг, улс ард аж ахуйн олон салбарын хөгжил, харилцаа тэлэн өргөжиж, нийгэм, оюуны санааны амьдралд хөгжил дэвшлийн дараачийн шинэ зорилт эрхгүй дэвшигдэн гарч ирсний учир, 1960 онд Монгол Улс, гурав дахь шинэ Үндсэн хуулиа баталж, хөгжлийн замналаа томъёолжээ.

Монгол Улсад 1950-иад оноос эхлээд орчин үеийн шинжлэх ухааны олон салбараар эрдмийн зэрэг хамгаалсан дэд эрдэмтэн, докторын эгнээ бий болж, тэд байгаль, нийгэм, хөдөө аж ахуй, анагаах зэрэг олон шинжлэх ухааны онол практикийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, цөөнгүй тохиолдолд нээлтийн, онолын байгуулалтын түвшинд хамтын болон бие даасан судалгаа хийж эхэлсэн нь эх орны оюуны салбарын томоохон дэвшил болсон байна.

Нөгөө талаар дэлхийн II дайны дараа, дэлхийн хүчирхэг гүрнүүд Монгол Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн нь Монгол Улсын гадаад нэр хүндэд эерэгээр нөлөөлж, энэ хэрээр Монгол Улс гадаад бодлогоо эрчимжүүлэн, зөвхөн хөрш зэргэлдээ улсын хүрээнд бус, бүс нутаг, олон улсын хэмжээнд аваачин, улмаар томоохон хэмжээний арга хэмжээ, үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, тэр хэрээр олон улсын тавцанд улсынхаа нэрийг мандуулж эхлэв. Ялангуяа Монголын эрдэмтэн, сэхээтнүүд олон улсын харилцаа, хамтын ажиллагаа, энх тайвныг сахин хамгаалах хөдөлгөөнд санаачилгатай ажиллаж, хүн нийтийн өмнө тулгамдаж буй оюун санааны асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг хүлээн, гүйцэтгэж эхэлжээ. Монгол Улс 1946 оноос эхлэн НҮБ-д элсэх өргөдлөө нийтдээ 9 удаа (1946, 1947, 1948, 1949, 1952, 1955, 1956, 1957, 1961 онд) өгч, 9 дэх өргөдөл, 5 дахь оролдлого дээрээ НҮБ-ийн бүрэн эрхт гишүүн болов.

Ингэж дотоод дахь нийгэм оюун санааны таатай нөхцөл, цаг үе, гадаад орчны хамтын ажиллагаа, дэмжлэг, Монгол орны зөв санаачилга, идэвхитэй байр суурь зэрэг, олон хүчин зүйл шүтэн барилдлага болж чадсаны нэгэн үр дүн нь Монгол Улсын ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ байгуулагдсан явдал болсон билээ. Энэ үйл хэрэгт гарамгай гавьяа байгуулсан хүн бол Академич Базарын Ширэндэв юм.

“... Би Москвад тийнхүү эрдэм шинжилгээний ажил хийж, 1960 он хүртэл ажиллахдаа, төлөвлөгөөт ажлынхаа сэдвийг бичихийн зэрэгцээ мэргэжлээ дээшлүүлэх зорилгоор англи хэл заалгаж, Москвагийн Эрдэмтдийн ордонд болдог лекцэнд тогтмол шахуу суув. Энэ ордонд Зөвлөлтийн төрөл бүрийн мэргэжлийн

нэрт эрдэмтэн академич, сурвалжлагч гишүүн, доктор профессорууд маш сонирхолтой лекц, яриа тусгай программаар явуулдаг байсан юм. Түүхийн шинжлэх ухааны арга барилаар академич М.Нечкина, профессор М.Ростовцев зэрэг мэргэжилтний хэд хэдэн удаагийн лекцийг сонссон. Мөн түүхийн судлалын гол асуудал - гар бичмэл ба түүхийн сурвалж бичгийг хэрхэн ашиглан, үнэлэхтэй холбогдсон сонирхолтой лекцүүд явагдана. Үүнд: Түүх, Философи, Социологи, Олон улсын байдал, Эдийн засаг зэрэг сэдвээр явагдаж байсан лекцэнд би голдуу суух боловч заримдаа Цөмийн физик, Биологи, Геологи, Хими, Одон орны зэрэг сэдвээр явагдаж байсан сонирхолтой ярианд сууна. Үүнээс шинжлэх ухаан техникийн хувьсгал эхэлж буй хөгжингүй орнуудад онцгой анхаарч шинэ, шинэ чиглэлийн ХҮРЭЭЛЭН зэргийг бий болгоход, их хэмжээний хөрөнгө зардал гаргадаг байна. ЗХУ-д Холбооны бүгд найрамдах улсуудад ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИТАЙ болж, боловсон хүчнийг эрчимтэй бэлтгэн, эрдмийн ажлыг өрнүүлэн байгааг ухварлан манай орон энэ талаар анхаармаар хэмээн санагдаж билээ.”<sup>7</sup>

гэсэн гэгээн, гэгэлгэн хүслээ тээсээр, эх орондоо хүрэлцэн ирсэн Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Б.Ширэндэвийг 1960 онд Шинжлэх Ухаан Дээд Боловсролын Хүрээлэнгийн даргаар томилсон байна. ШУДБХ-ийн дарга, доктор, профессор Д.Цэвэгмидийг, Гадаад явдлын яамны Нэгдүгээр орлогч сайдаар томилсон нь “чухамдаа олон улсын хамтын нийгэмлэг рүү хандуулсан томилгоо байсан бөгөөд ... Монголчуудыг болхи бүдүүлэг, эрдэм номгүй харанхуй хүмүүс гэж гадаадынхан үздэг байсан тэр үед, Биологийн шинжлэх ухаанд нээлт хийж, СССР-т эрдмийн зэрэг хамгаалсан, улсынхаа цорын ганц тэргүүлэх их сургуулийг удирдаж байсан тэр хүнийг, улсаа төлөөлүүлэн НҮБ руу илгээх нь танилцуулгаасаа эхлээд сэтгэгдэл төрүүлэх, НҮБ-ын хурлын дарга нарт зориуд нөлөөлүүлэх гэсэн хэрэг байлаа”<sup>8</sup>.

Ингээд доктор Б.Ширэндэв, ШУДБХ-ийн даргын албыг хүлээн аваад, ажилдаа шамдан орсон нь улс, нийгмийн хөгжилд ихээхэн ирээдүйтэй бөгөөд үйл ажиллагааны хувьд өвөрмөц онцлогтой ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ-г байгуулах, улмаар ШУА-аас Дээд боловсролын хороо нь тусдаа байх саналыг боловсруулан, Төв Хороо, Засгийн газарт өргөн барих явдал байв.

ШУДБХ-ийн дарга Б.Ширэндэв, академи байгуулах үндэслэл, тооцоо зэрэг бүхий л асуудлаа боловсруулсан төслийг дээд байгууллагдаа өргөн барьжээ. Түүний төслийг МАХН-ын Төв Хороо, Засгийн газар удаа дараа авч хэлэлцээд, 1960 оны 10-р сарын 13-ны өдөр хуралдсан МАХН-ын Төв хорооны хурлаас “1961 онд ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ байгуулах” шийдвэр гаргасан байна. Ийнхүү ШУА байгуулах ажил албан ёсоор өрнөж эхэллээ. Заасан хугацаанд, батлагдсан төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлыг амжилттай гүйцэтгэн тайлагнаж, хамгаалсны учир, 1961 оны 5-р сарын 16-нд Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн газраас ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ байгуулах зарлиг гаргасан байна. Нэгэнт АИХ-ын Тэргүүлэгчийн зарлиг буусан учраас Сайд нарын зөвлөл

<sup>7</sup> Б.Ширэндэв. “Далайн давалгаанаар” (туужчилсан роман), УБ,1993, 254-255-р тал

<sup>8</sup> Д.Баярхүү “Монгол тулгатны 100 эрхмийн нэг-дипломатч Дондогийн Цэвэгмид”, “Академич Д.Цэвэгмид:Дурсгалын түүвэр”, эмхэтгэж, редакторласан Б. Мөнхбаяр, УБ, 2015, 154-р тал

хуралдан, 1961 оны оны 5-р сарын 22-ны өдрийн хурлын 257 дугаар тогтоолоор ШУА-ийн дүрмийг баталлаа. ШУА-ийн бүрэлдэхүүнд 9 академич, 19 сурвалжлагч гишүүн байхаар зааж өгөв.

Ийнхүү нэгэнт эрх зүйн талаасаа асуудал шийдэгдсэн учир, мөн өдрөө ШУА-ийнхаа анхны чуулганаа хуралдуулж, 7 хүний бүрэлдэхүүнтэй Тэргүүлэгчдийн газараа байгууллаа. Сайд нарын зөвлөлөөс баталсан орон тооны хүрээнд академичаа сонгосон байна. Үүнд: Ц.Дамдинсүрэн, Н.Жагварал, Ш.Лувсанвандан, Б.Ринчен, Ц.Тойвгоо, Д.Төмөр-Очир, Т.Шагдарсүрэн, Б.Ширэндэв, Ш.Нацагдорж нарын 9 эрдэмтэнд Академич цол олгож, ШУА-ийн Ерөнхийлөгчөөр, Академич Б.Ширэндэвийг, Эрдэмтэн нарийн бичгийн даргаар Сурвалжлагч гишүүн Ч.Сэрээтэрийг, гадаад гишүүдээр Зөвлөлтийн эрдэмтэн, физикч, Академич М.В.Келдыш, Газар зүйч, туйл судлаач Академич Е.К.Федоров, Энэтхэгийн философич Сарвапалли Радха-Кришнан, Хятад утга зохиол судлаач Го Мо Жо, Унгарын монголч эрдэмтэн Лайош Лигети, Польшийн философич Тадеуш Каторбински нарыг сонгожээ.

ШУА-ийн үндсэн бүтцийн хүрээлэнд Хэл зохиолын хүрээлэн, Түүхийн хүрээлэн, Хөдөө аж ахуйн хүрээлэн, Байгалийн ухааны хүрээлэн байхыг зааж, ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН-гийн захирлаар Академич Ц.Дамдинсүрэнг сонгон баталлаа.

Энэ бүхний эцэст МАХН-ын Төв хороо 1961 оны 5-р сарын 24-ны өдөр Монгол Улсын ШУА-ийг баяр ёслолын байдалтай нээхээр болж, ШУА байгуулагдсан баярын хуралдаан зохион байгуулахад төр засаг, дотоодын олон нийтийн байгууллага, ард нийт, иргэдээс, гадаадаас, тухайн үеийн холбоот улсуудын шинжлэх ухааны академиуд, шинжлэх ухааны зүтгэлтэн эрдэмтэн мэргэдээс баярын илгээлт олон ирүүлжээ. Хурлын индрээс Монгол Улсын ШУА-ийн анхны Ерөнхийлөгч Б.Ширэндэвийн хэлсэн:

“Манай эрдэмтэд хэрэв энэ өдөр эс чадвал маргааш гэхэд, манай өгөөмөр өлгий нутгийнхаа үнэт эрдэнэсийг заавал уудлан олж, эх орноо элбэг баян, тэргүүний орон болгож чадна. Манай шинжлэх ухаан маргааш эс чадвал нөгөөдөр гэхэд манай хөрсөн дээр байгаа охь баялаг болох газар тариалан, мал аж ахуй, ой мод, гол мөрөнг бүрэн сайн ашиглахад тус болно. Энэ ирээдүйн их ажлын хугацааг аль болохоор богиносгож хурдан биелүүлэхийг бид чармайна. Шинжлэх ухааны хүчээр өвлийн тэсгим хүйтнийг зөөлрүүлж, ширүүн салхийг номхотгож, говийн хөрсийг чийгжүүлэх цаг ирнэ хэмээн итгэж байна.”<sup>9</sup>

гэсэн цогт бадрангуй, эх оронч, эрмэлзэл дүүрэн дуу хоолой тод дуурссан нь, эдүгээ гэрэлт хөшөөний бичээс болон мөнхөрсний зэрэгцээ, нэгэн жарны дараах энэ цагт, бодит биелэлээ бүрнээ олсон нь бахархалтай хэрэг мөн.

Нэн сайхан нь, өдгөөгөөс нэгэн зууны өмнө, шинэ цагийн шинжлэх ухааны ууган байгууллага - Судар бичгийн хүрээлэнгийн Эрхэлсэн сайд Онход Жамьян гүний:

“Шинжлэх ухааны алс зорилт нь болбоос, хүний эрдэм соёлыг мандуулан, амь биеийг хорлох аюулаас хамгаалан, хүн төрөлхтний ухаан ба эдийн боловсролд

---

<sup>9</sup> Б.Ширэндэв. “Далайн давалгаанаар” (туужилсан роман), УБ, 1993, 263-р тал

саад бологч харш нөхцлүүдийг урьдаас арилган тустай нөхцлүүдийг бүртгэхүй нь болой. Тус улсад шинжлэх ухааныг дэлгэрүүлэн аливаа шинжлэгдэхүүн зүйлийг шинжлэн магадалж, элдвийн соёл, эрдмийн явдлыг удирдан эрхбиш шинжлэх ухааны гол газар байх хэрэгтэй бөгөөд олон улсад зонхи ухаан бүгдийг бүртгэсэн “Академи” хэмээхийг нээсээр хэд, хэдэн зуун он өнгөрчээ. Монгол Улсад мөнхүү энэ мэт шинжлэх ухааны гол газар эрхбиш байгуулваас зохимуй. Санаваас эдүгээ бүхий манай Судар бичгийн хүрээлэн байн, байсаар хөгжин дэлгэрч, ухаан бүгдийг бүртгэсэн ба уран сайхны ажлыг хураан цогцолсон Академи болж чадах буй за”<sup>10</sup>

ХЭМЭЭН,

Тийн итгэн найдсаныг нь  
Дөрвөн аравны дараа  
Ийн гүйцэтгэн, хүслийг биелүүлснийг нь  
Нэгэн жарны өндөрлөгөөс  
Нэхэн бичиж буй нь  
Нэгэн насны буян буюу ...

Ингэж Монгол Улсын ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ хийгээд ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН хоёр нь нэгэн өдөр, нэгэн тулганд, хамтын галаа асаан бадраасан нь, бадамлан түгэж, тэр байтугай Судар бичгийн хүрээлэнгийн Дуун ухааны тасаг (1921) -ийн, Шинжлэх ухааны хүрээлэнгийн Хэл бичгийн кабинет (1930)-ын, Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэнгийн Хэл утга зохиол судлах газар (1957)-ын, Хэл зохиолын хүрээлэн (1961)-ийн ГУРВАН Эрдэм шинжилгээний ажилтан нь Монгол Улсын ШУА-ийн анхны жинхэнэ гишүүн - Академич болсон нь, мөн түүнчлэн БНХАУ-ын ШУА-ийн Ерөнхийлөгч, Утга зохиол судлаач Го Мо Жо, БНУАУ-ын ШУА-ийн дэд ерөнхийлөгч, хэл соёл судлаач Лайош Лигети нарын зэрэг Дорно дахины болон Монгол судлалын нэрт эрдэмтэд Монгол Улсын ШУА-ийн гадаад гишүүнээр сонгогдсон нь, нэг талаас ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН хэмээх эрдмийн өргөө гэрийн нэр хүндийн илэрхийлэл, нөгөө талаас Судар бичгийн хүрээлэнгийн Дуун ухааны тасгаас Хэл зохиолын хүрээлэн хүртлэх нэр бүхий эрдмийн байгууллагын НОМЫН МЭРГЭД НАР НЬ Монгол Улс, Монгол үндэстэн нартаа эрдэм дэлгэрүүлэх, соён гэгээрүүлэх үйл хэргийг ямагт мандуулж ирснийг батлан харуулсан, эх орны хэл бичгийн шинжлэх ухааныг өрнүүлэн бадруулсан байр суурийг нь илэрхийлсэн хэрэг болсон нь өнөөгийн өндөрлөгөөс тод харагдаж байгаа юм.

---

<sup>10</sup> “Монгол Улсын Судар бичгийн хүрээлэнгийн эрхлэх үйлдвэрийн товчоо” Өргөө, 1924 он, 2-р тал

## ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Энэхүү бүтээл нь:

- ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн хөгжлийн түүхийн судалгаа хараахан хийгдээгүй байсан нөхцөлд, тус хүрээлэнгийн түүхэн хөгжлийн 100 жилийн явц байдал, үечлэл зааг, уламжлал шинэчлэл, харилцаа холбоо, хамтын ажиллагааны мөн чанар тодорч, хожим хойч, дараачийн үед хийгдэх шинжлэх ухаан судлалын нэгэн уламжлалыг бий болгосноороо
- Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм судлалын үйл ажиллагааны өв уламжлал, өнөөгийн байдалдаа үнэлэлт дүгнэлт өгснөөр цаашдын хөгжлийн хандлага, алсын хараа ямар байх үндсэн чигийг тогтоож өгснөөрөө
- Тус бүтээлийн үр дүнд тулгуурлан, хүрээлэнгийн өв уламжлал хийгээд өнөөгийн эрдэм судлалын байдлыг багтаасан өгөгдлийн сан бүрдүүлэх ач холбогдолтой болж байгаараа
- Тус бүтээлийн үр дүнд үр дүнд Монгол хэл хэлбичгийн шинжлэх ухааны хөгжилд оруулсан эрдэмтдийн хувь нэмрийг, өнөөгийн шинжлэх ухааны хөгжил дэвшил онол арга зүйн үүднээс дахин шинээр авч үзэж тодорхойлсон нь ач холбогдолтой болсон. Өөрөөр хэлбэл үндэсний хэл бичгийн шинжлэх ухааны хөгжлийн уламжлалын асуудал улам тодорч, залгамж чанар, харилцаа холбооны асуудлыг шинэ түвшинд авч үзэх бололцоог өгч байгаагаараа

чухал ач холбогдолтой бүтээл болсон гэж дүгнэж байгаа юм.